



БАЯНЗҮРХ ЭМНЭЛЭГ ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2024 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 4/39

Улаанбаатар хот

Эмнэлгийн ажилтанд ажлын гүйцэтгэл,  
үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох  
журам шинэчлэн батлах тухай

Монгол улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.6.2, 16.6.3, 16.7.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.1, Төрийн абаны тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1, Засгийн газрын 2019 оны 05, 395 дугаар тогтоол, Эмнэлгийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1.2, Хөдөлмөрийн дотоод журмын 2 дугаар зүйлийн 2.7.3-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Эмнэлгийн эмч, ажилтнуудын ажлын үр дүн, гүйцэтгэлээр мөнгөн урамшуулал олгох журам"-ыг нэгдүгээр хавсралтаар, "Ажлын үр дүн, гүйцэтгэлийг дүгнэх шалгуур үзүүлэлт" (Хүснэгт 1, Хүснэгт 2, Хүснэгт 3)-ийг хоёрдугаар, "Оноо тавих хүснэгт"-ийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг удирдлага, арга зүйгээр ханган ажиллахыг Хүний нөөц, хөгжлийн албанд даалгасугай.

3. Энэхүү журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч (А.Билэгжаргал)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2022 оны 09 дүгээр сарын 26-ний А/25 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ө.АЙГИЙМАА

## ЭМНЭЛГИЙН ЭМЧ, АЖИЛТНУУДЫН АЖЛЫН ҮР ДҮН, ГҮЙЦЭТГЭЛЭЭР МӨНГӨН УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар тус эмнэлгийн ажилтны сарын ажлын гүйцэтгэл, үр дүнг үндэслэн мөнгөн урамшуулал олгохтой холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн тогтолцооны шинэчлэлийн хүрээнд Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр санхүүжих үйл ажиллагаа бүрэн хэрэгжсэнтэй холбогдуулан ажилтны ажлын гүйцэтгэл үр дүнг чанарын үзүүлэлтэй уялдуулан дүгнэнэ.

### Хоёр. Эмнэлгийн ажилтанд ажлын гүйцэтгэл, үр дүнгээр мөнгөн урамшуулал олгоход тавигдах шаардлага, баримтлах шалгуур

2.1. Сар бүр ажилтны ажлын гүйцэтгэл, тусламж үйлчилгээний чанар, үр дүнгийн мөнгөн урамшууллыг Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтын хасагдал, алдагдалгүй ажилласан, ажлын гүйцэтгэл бүрэн ханган ажилласан, хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй ажилтанд олгоно.

2.2. Эмнэлгийн ажилтанд ажлын гүйцэтгэл, үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох зардлын шаардлагатай эх үүсвэрийг байгууллагын жил бүрийн төсөвт тусган, ажилтны ажлын гүйцэтгэл, үр дүнд үндэслэн шалгуур хангасан сар бүр төвүүдийн захирал 800.000, албадын дарга, тасгуудын эрхлэгч 700.000, төв, тасгуудын менежер, их эмч нар, инженерүүд, захиргааны ажилтнууд 500.000, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн 400.000, дэмжих үйлчилгээний ажилтан (үйлчлэгч, слесарь, харуул г.м) нарт 300.000 төгрөгийг олгоно.

2.3. Төв, тасгуудын захирал, эрхлэгч, албадын дарга, менежерүүдийн ажлыг тухай бүрд томилогдсон ажлын хэсэг дүгнэж үнэлнэ.

2.4. Тухайн нэгжийн шууд удирдах албан тушаалтан нь ажилтны өдөр тутмын ажлын гүйцэтгэл, үр дүн, чанар, өгсөн үүрэг даалгаврын биелэлт, хамтран ажиллагч болон үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, тасаг нэгжийн үйл ажиллагааны оролцоо идэвх, ажлын цаг ашиглалт түүний үр дүнтэй байдлыг тоон үзүүлэлтээр шударга зарчмыг баримтлан дүгнэнэ.

2.5. Төв, тасгуудын эрхлэгч, албадын дарга нар нь өөрийн хариуцсан нэгжийн ажилтнуудад өгөх үнэлгээг шалгуурын дагуу ашиг сонирхолын зөрчил гаргахгүйгээр дүгнэн нэгдсэн дүнг дараа сарын сарын 07-ны дотор Хүний нөөцийн хөгжлийн албаны хүний нөөцийн менежерт хүлээлгэн өгч баталгаажуулна.

2.6. Дараах тохиолдолд гүйцэтгэлийн мөнгөн урамшуулал олгохгүй:

2.6.1. Шинээр ажилд орсон эхний 1 сард,

2.6.2. Ажлын 3 ба түүнээс дээш хоног ямар нэгэн шалтгаанаар ажиллаагүй тохиолдолд,

2.6.3. Тухайн сард эмнэлгийн гүйцэтгэх захирлын тушаалаар хөдөлмөрийн сахилгын шийтгэлтэй бол,

2.6.4. Засгийн газрын 11-11 болон дээд газарт мэдээлэгдсэн гомдол нь тухайн төв, тасгийн тусламж үйлчилгээтэй холбоотой тохиолдолд захирал, эрхлэгч, менежер, эмч ажилчдаас гүйцэтгэлийн урамшууллыг 10-30 хувиар тооцон хасаж олгоно.

2.6.5. Ажлын байрны албан болон албан бус тасралтгүй сургалт, удирдлагын шуурхай зөвлөгөөний ирц 80 хувьд хүрээгүй бол,

2.6.6. Эмнэлгийн чанарын хяналтын хурал, консилиум конференцийн оролцоо, эмнэлгийн захиргаанаас зохион байгуулсан нэгдсэн үйл ажиллагаанд оролцоогүй бол,

2.6.7. Захирлын зөвлөлийн хурал, эмнэлгийн чанарын хяналтын хурал, консилиум конференцийн хуралаас анхааруулга авсан тохиолдолд,

2.6.8. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн зөрчил гаргасан нь ёс зүйн хорооны шийдвэрээр батлагдсан бол,

2.6.9. Хөдөлмөрийн гэрээний заалтыг зөрчсөн бол.

2.6.10. Онцгой үр бүтээлтэй ажилласан, шинэ технологи нэвтрүүлсэн, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлсэн эмнэлгийн ажилтанд тухайн сард мөнгөн урамшууллыг шалгуур үзүүлэлт харгалзалгүйгээр, захирлын тушаалаар нэмэлтээр олгож болно.

### **Гурав. Эмнэлгийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлээр ажил дүгнэх аргачлал**

3.1. Ажлын үр дүнгийн үнэлгээнээс хамааран сар бүрийн мөнгөн урамшууллыг 70-100 оноогоор дүгнэж, хувиар тооцон олгоно.

3.2. Урамшуулал нь 69-оос доош хувьтай дүгнэгдсэн бол урамшуулал олгохгүй.

### **Дөрөв. Бусад**

4.1. Эмнэлгийн ажилтанд ажлын гүйцэтгэл, үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох батлагдсан журмыг нийт ажилтнуудад танилцуулан мэдээлж, эмнэлгийн дотоод сүлжээнд ил тод, нээлттэйгээр байршуулна.

4.2. Ажилтны ажлын гүйцэтгэл, үр дүнг бодитоор үнэлэх тогтолцоог улам бүр боловсронгуй болгох зорилгоор хагас жил тутамд өөрийн байгууллагын хэрэгжилтийн байдал, гүйцэтгэл үр дүнгийн тогтолцооны сайн туршлагаудыг бусад байгууллагуудаас судлан журамд өөрчлөлт, шинэчлэлт, сайжруулалт хийж болно.

4.3. Эмнэлгийн ажилтны ажлын гүйцэтгэл, үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох шалгуур үзүүлэлтийг үндэслэн дүгнэх чиг, үүрэг, албан тушаалтнууд нь аливаа ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, хувийн шинжтэй болон мэргэжлийн үйл ажиллагааны хамаарал үүсгэхгүй байхад онцгой анхаарч ажиллах бөгөөд энэхүү үйл ажиллагаанд хариуцлагагүй хандсан тохиолдолд өөрийнх нь хариуцлагын үнэлгээг бууруулна.

232

4.4. Тухайн улирлын үнэлгээнд ашигласан баримт нотолгоо, тайлан мэдээг томилогдон ажилласан ажлын хэсгийн бүрэлдэхүүн нь холбогдох журам, стандартын дагуу баримтжуулан архивт хүлээлгэн өгнө.

4.5. Энэхүү журмыг зөрчсөн нь нотлогдсон тохиолдолд холбогдох хууль, тогтоол, байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

xxx